

“DE/ANTI-ICING” TYPE-IV ТӨРЛИЙН ТУСГАЙ ШИНГЭНИЙ ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Зориулалт:

Агаарын хөлгийг мөстөлтөөс хамгаалах болон хөлгийн гадаргууд тогтсон цас, мөсийг арилгах зориулалттай, агаарын хөлгийн нислэгийн аюулгүй ажиллагааг бүрэн хангаж, хөлгийн гадаргуу дээр цас, мөс тогтохоос сэргийлэх максимум хамгаалалт /Holdover time/ санал болгох зориулалт бүхий тусгай шингэн байна.

Шингэний төрөл: TYPE IV төрлийн шингэн,

CLARIANT SAFEWING MP IV LAUNCH болон CLARIANT SAFEWING MP IV LAUNCH PLUS, CRYOTECH POLAR GUARD® ADVANCE төрлийн шингэн болон түүнтэй дүйцэхүйц.

Стандарт:

“De/anti-icing” , Type-IV маркийн тусгай шингэн нь олон улсын SAE/ AMS-1428, SAE/ AMS-1424, ISO-11075, ISO-11076, ISO-11078 стандартын шаардлага хангасан бүтээгдэхүүн байна.

Тусгай шингэн нь олон улсын итгэмжлэгдсэн “AMIL” лабораториар баталгаажсан байхаас гадна байгаль орчинд хоргүй, хөрс, усанд бүрэн шингэдэг эко шингэн байна. Шингэний хадгалалтын хүчинтэй хугацаа нь нийлүүлэгдсэн өдрөөс хойш 21 сар буюу түүнээс дээш хугацаатай байна.

Савалгаа: 1000 литрийн савалгаатай

Ерөнхий шаардлага:

Манай улстай цаг агаарын хувьд ойролцоо олон улсын нисэх буудлуудад ашиглагдаж байгаа нь тодорхойлогдсон байна. TYPE IV төрлийн шингэн нь 2024-2025 оны өвлийн улиралд “ FAA Holdover Time Guidelines ” жагсаалтанд орох боломжтой байх ёстой ба шингэнийг нийлүүлэх, хүлээн авахад энэ жагсаалтад багтаагүй тохиолдолд хүлээн авахаас татгалзах үндэслэл болно.

Тендерийн бичиг баримтад шингэнийг үйлдвэрлэгч компанийн лизенцийг хавсаргасан байна.

Техникийн үзүүлэлт:

Физик болон үйлчлэлийн шинж чанар: Усан суурьтай MPG /моно пропилений гликоль/ хольцтой, гликолийн агууламж 50% доошгүй ногоон өнгийн шингэн байна.

а. LOUT /Ажиллагааны үед ашиглах доод температур/ Шингэн/ Усны найрлага	100%-д	°C	-28,5 -30,5
	75%-д		-14
	50%-д		- 3
б. Шатах цэг/ °C			>100(>212)
в. pH Орчин (20°C/32°F)			6,5-7,5
г. Таталцал /20° C/68° F/			1.023-1.053
д. Гадаргуугийн таталцал 20°C/68°F/ dynes cm ⁻¹			24,3-29,7

е. Хугарлын индекс	(20°C/32°F)	1.3900-1.3930
ж. Вrix буюу сахарын агууламж	(20°C/32°F)	34,7-36,5
з. Дулааны тогтвортой байдал	(70° C/158° F, 30 өдөр)	WSET=95 min
и. Усны хатуулгийн тогтвортой байдал	50/50 95°C,30 өдөр	WSET=8 min
к. Нэвтрэх хүчний тогтвортой байдал		Наалдамхай чанар10% буурна.
Динамик зууралдлага: /mPas/	20 °C	25.000
	-25°C	12.000
л. Хөлдөх цэг		°C
Шингэн/ Усны найрлага	100%	-37,0.....-39,0
Шингэн/ Усны найрлага	75%	-21,4
Шингэн/ Усны найрлага	50%	-9,0
м. WSET/Ус шүршилтийг тэсвэрлэх чадварын тест/		min
Шингэн усны найрлага	100%	100
Шингэн усны найрлага	75%	80
Шингэн усны найрлага	50%	15
н. ННЕТ/ Өндөр чийгшилтийг тэсвэрлэх чадварын тест/		min
Шингэн усны найрлага	100%	>12
Шингэн усны найрлага	75%	>12
Шингэн усны найрлага	50%	2

Шингэнийг үйл ажиллагаанд ашиглах шаардлага:

Манай орны эрс тэс цаг уурын нөхцөл байдалд тохирсон дараахь үзүүлэлтээр үйл ажиллагаанд ашиглах шаардлагыг хангана.

Үүнд:

- Орчны температур -3⁰ хүртэл шингэний найрлага 100%, 75/25%, 50/50% харьцаатайгаар ашиглах
- Орчны температур -3⁰C - -14⁰ C хүртэл шингэний найрлага 100%, 75/25% харьцаатайгаар ашиглах
- Орчны температур -14⁰C болон түүнээс доош температурт шингэний найрлага 100% харьцаатайгаар ашиглах шаардлагыг хангах ёстой.

Хур тундасны орох эрчимжилтээр хамгаалалт барих хугацаагаар дараах шаардлагыг хангасан байх ёстой.

Үүнд:

-25°C болон түүнээс доош температурт Very Light Snow, Snow Grains or Snow хур тундастай үед хамгаалалт барих хугацаа 0:20-0:30 мин, Light Snow, Snow Grains or Snow хур тундастай үед 0:06-0:20 мин, Moderate Snow, Snow Grains or Snow хур тундастай үед 0:01-0:06 минутаас тус тус багагүй буюу түүнээс дээш байна.

Дараахь шаардагдах бичиг баримтыг шингэн нийүүлэлтийн хийхэд дагалдуулна.

Үүнд:

- Шингэний үйлдвэрийн гарал үүслийн бичиг
- Чанарын шинжилгээний хуудас
- Тоо, хэмжээг заасан бичиг баримт
- Тээвэрлэлтийн бичиг баримт
- Шингэний хадгалалтын хугацааг нотолсон үйлдвэрлэгчийн бичиг
- Үйлдвэрлэсэн огноо
- Шингэн усны найрлагад агуулагдах хугарлын индекс, сахарын агууламж, хөлдөх цэгийн тодорхойлолтын хүснэгт